



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/343

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5./а/, 29.2 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10.1.2, 10.1.7 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орхон аймагт спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа Төрийн бус байгууллагуудын дунд 2017 оны 06 дугаар сарын 14-нөөс 07 дугаар сарын 02-ны өдрүүдэд болох спортын дасгалжуулалт онол арга зүй, практик хосолсон сургалтын үйл ажиллагаанд 3360000 төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах 3360000 /Гурван сая гурван зуун жаран мянган/ төгрөгийг Засаг даргын нөөц сан хуваарилагдаагүй бусад зардлын “Боловсрол, эрүүл мэнд, спорт, урлагийн салбарын ажиллагсдын мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зардал”-аас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д. БАТЛУТ